



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 09 сарын 01 өдөр

Дугаар A/99

Жаргалтхаан сум

**Ойн цэвэрлэгээний арга хэмжээг
хэрэгжүүлэх тухай**


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.1, 18.2.2 дахь заалт, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газрын даргын 2025 оны A/78 дугаар тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын Чулуут багийн нутаг Дарийн даваа гэх газар буюу ойн сангийн 11 дүгээр хэсэглэлийн 6, 8, 11, 12 дугаар ялгарал дахь 99 га талбайд ойн цэвэрлэгээний арга хэмжээг хэрэгжүүлэхийг Зоос булаг ХХК-д зөвшөөрсүгэй.

2.Ойн цэвэрлэгээний арга хэмжээг хэрэгжүүлэх талбайд цэвэрлэгээний ажил, цэвэрлэгээний огтлолтын арга хэмжээг хамтад нь хэрэгжүүлэх мод бэлтгэлийн талбай тусгаарлалт хийх, тухайн талбайгаас гарах нөөцийг тодорхойлох, тухайн талбайд өөрийн хөрөнгийн нөхөн сэргээх талбайн хэмжээг мод бэлтгэх гэрээнд тусган, хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулахыг Хэнтий шинэс сум дундын ойн ангийн дарга /Б.Давхарбаяр/-т даалгасугай.

3.Нөөц ашиглах эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээ олгох, ойн цэвэрлэгээний арга хэмжээг хэрэгжүүлэх ажилд хяналт тавьж ажиллахыг байгаль хамгаалагч /Х.Намхайдорж /-д, мод бэлтгэх эрхийн бичиг, мод, модон материалын гарал үүслийн гэрчилгээнд хяналт тавьж ажиллахыг байгаль орчны хяналтын улсын байцаагч /Г.Түмэнжаргал /-д даалгасугай.

ДАРГА



С.ГАНБАТ